



САНХҮҮГИЙН  
ЗОХИЦУУЛАХ  
ХОРОО

# ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ҮЙЛЧИЛГЭЭ ҮЗҮҮЛЭГЧИЙН САЛБАРЫН

*ХОЁРДУГААР УЛИРЛЫН НЭГДСЭН ТАЙЛАН*

# 2024





## Агуулга

- 01 ЕРӨНХИЙ ТАНИЛЦУУЛГА
- 02 ВХҮҮ ДЭЭР АРИЛЖААЛАГДАЖ БУЙ ДОТООД БОЛОН ГАДААД ВИРТУАЛ ХӨРӨНГИЙН ТОО
- 03 ВХҮҮ-ИЙН АРИЛЖААНЫ ЗОХИОН БАЙГУУЛАЛТ
- 04 ХАРИЛЦАГЧИЙН МЭДЭЭЛЭЛ
- 05 МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭРСДЭЛ
- 06 САНХҮҮ ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТ

## ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

- Хүснэгт 1. Бүртгэлтэй ВХҮҮ–дийн мэдээлэл
- Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл
- Хүснэгт 3. ВХҮҮ дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл
- Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч
- Хүснэгт 5. МУТСТ эрсдэлийн үнэлгээ
- Хүснэгт 6. Орлогын дэлгэрэнгүй тайлан

## ЗУРГИЙН ЖАГСААЛТ

- Зураг 1. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Зураг 2. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн
- Зураг 3. Дотоод болон гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ
- Зураг 4. Нийт харилцагчдын мэдээлэл
- Зураг 5. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал

## ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

ВХ	Виртуал хөрөнгө
ВХҮҮ	Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч
УТНБЭ	Улс төрийн нөлөө бүхий этгээд
МУТСТ	Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх

## Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн хураангуй танилцуулга


2024 оны хоёрдугаар улирлын байдлаар Санхүүгийн зохицуулах хороонд нэр бүхий 12 ВХҮҮ бүртгэлтэй байна. Доорх хүснэгтэд бүртгэлтэй ВХҮҮ-ийн товч мэдээллийг харуулав.

Хүснэгт 1. Бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Регистрийн дугаар	Үүсгэн байгуулагдсан огноо	Бүртгэл олгосон огноо	ВХҮҮ-ийн платформын хаяг	Үйл ажиллагааны чиглэлийн тоо
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	6210139	2017.08.01	2022.09.21	Trade.mn	5
2	“Койн Хаб” ХХК	6693326	2021.04.06	2022.09.21	Coinhub.mn	5
3	“Айдакс” ХХК	6803016	2021.12.30	2022.09.21	Idax.exchange	5
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	3645789	2021.09.23	2022.10.10	Ncx.mn	3
5	“Корекс” ХХК	6752586	2021.09.07	2022.10.10	Corex.mn	5
6	“Икс Мета” ХХК	6784771	2021.11.18	2022.10.10	X-meta.com	5
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	6719791	2021.06.20	2022.10.10	Complex.mn	5
8	“Чойжин Алтекс” ХХК	6785123	2021.11.18	2022.10.10	Altex.mn	5
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	6671845	2021.03.04	2022.10.10	Zoos.digital	5
10	“Капекс капитал” ХХК	6792987	2021.12.07	2022.11.25	Capex.mn	3
11	“Анд дэнөүд” ХХК	6783147	2021.11.12	2022.11.25	Denode.io	5
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	6906834	2022.08.25	2023.01.13	Octagon.mn	5

Дээрх нэр бүхий 12 ВХҮҮ-ээс 11 нь Улаанбаатар хотод байршилтай бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК нь Өмнөговь аймгийн Даланзадгад суманд байршилтай байна. Түүнчлэн 12 ВХҮҮ-ээс 10 нь Виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-т заасан 5 үйлчилгээг үзүүлэхээр Хороонд бүртгүүлсэн бол “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК болон “Капекс капитал” ХХК нь виртуал хөрөнгө, албан ёсны мөнгөн тэмдэгт хооронд арилжих, виртуал хөрөнгийг шилжүүлэх, виртуал хөрөнгө, түүнд хамаарах хэрэгслийг хадгалах, удирдах гэсэн 3 үйлчилгээг үзүүлэхээр бүртгэл хийлгэсэн.


## ВХҮҮ дээр арилжаалагдаж буй дотоод болон гадаад виртуал хөрөнгийн тоо



2024 оны хоёрдугаар улирлын байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан нийт 724 виртуал хөрөнгө арилжаалагдаж байгаа бөгөөд үүнээс 45 дотоодын виртуал хөрөнгө, 679 гадаадын виртуал хөрөнгө байна. Нийт арилжаалагдаж буй виртуал хөрөнгийн 93.7%-ийг гадаадын виртуал хөрөнгө эзэлж байна.


## ВХҮҮ-ийн арилжааны зохион байгуулалт

Зураг 1. Дотоод виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн \тэрбум төгрөг\



Зураг 2. Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны дүн тгэрбум төгрөг\


■ 2024 оны нэгдүгээр улирал  
 ■ 2024 оны хоёрдугаар улирал



Хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчээр дамжуулан 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар нийт 420.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, өмнөх улирлаас 4.3%-иар өссөн байна. Үүнийг задлан харвал гадаадын виртуал хөрөнгийн 411.3 тэрбум төгрөг, дотоодын виртуал хөрөнгийн 9.02 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн бөгөөд “Капекс Капитал” ХХК, “Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК, “Поверэд Эй Ди Эм” ХХК дээр гадаадын виртуал хөрөнгийн арилжаа хийгдээгүй, харин “Чойжин Алтекс” ХХК, “Анд Дэнөүд” ХХК дээр дотоодын виртуал хөрөнгө арилжаалагддаггүй бол “Зоос Дижитал Эксчэйнж” ХХК дээр тус улиралд гадаад, дотоод виртуал хөрөнгийн арилжаа хийгдээгүй байна.

Гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны 62.7 хувийг “USDT”-ийн арилжаа эзэлж байна.

Зураг 3. Дотоод болон гадаад виртуал хөрөнгийн нийт арилжааны хэмжээ 2024 оны 2-р улирал тгэрбум төгрөг\



Дотоодын болон гадаадын виртуал хөрөнгийн нийт арилжааг сар бүрээр харуулбал дээрх байдалтай байна. 2024 оны 3 дугаар сард арилжааны хэмжээ хамгийн өндөр дүнтэй байсан бол 4 дүгээр сард арилжааны хэмжээ буурч, 5 дугаар сараас 6 дугаар сар хүртэл арилжааны хэмжээ аажмаар өссөн дүнтэй байна.

## Хүснэгт 2. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн мэдээлэл

№	Виртуал хөрөнгийн нэр	Анхны ханш	2024.04.01–ний өдрийн ханш	2024.06.30–ны өдрийн ханш	Улирлын ханшийн өөрчлөлт	2024.04.01–06.30 хүртэл нийт арилжааны хэмжээ (төгрөгөөр)	Зах зээлийн үнэлгээ
1	A100F	100.00	57.24	73.14	27.78%	55,990,177.00	1,462,589,058.00
2	A44L	44.00	33.71	28.78	-14.62%	46,859,650.00	549,386,675.00
3	A45J	45.00	20.67	25.6	24.85%	65,283,647.00	557,334,262.00
4	A47K	47.00	40.55	31.8	-21.57%	69,229,152.00	476,980,250.00
5	A55M	55.00	27.03	38.16	41.18%	90,298,183.00	1,107,849,474.00
6	A66H	66.00	52.47	55.65	6.06%	72,027,160.00	1,243,974,457.00
7	A77G	77.00	52.47	52.47	0.00%	74,655,098.00	1,573,950,896.00
8	A80E	80	64.87	63.6	-1.96%	33,213,953.00	1,271,836,650.00
9	BS9	–	1000.00	999.00	-0.1%	1,550,000,000.00	14,534,119,433.00
10	ADMC	1	0.282	0.268	-4.63%	10,545,970.16	308,703,126.37
11	ARDX	1	14.6	15.7	7.53%	1,985,869,953.87	12,204,038,139.75
12	ARDT	<sup>1</sup> DAXT=1 ARDX	2700.00	2001.00	-25.89%	17,910,502.00	6,160,070,540.00
13	BES	0.14	3.5	3.5	0.00%	–	863,965.98
14	BID	0.4	0.2	0.19	-5.00%	520,429.08	931,363,122.73
15	CHB	30	22.36	14.56	-34.84%	223,632,652.77	12,382,528,911.89
16	IHC	0.30	0.078	0.064	-17.34%	803,329,915.79	42,622,454,321.72
17	SPC	0.2	0.2097	0.1956	-6.69%	977,408,533.08	14,483,618,082.05
18	MNFT	0.3	0.0424	0.0423	-0.35%	277,094,177.2	5,353,282,262.8
19	MNDT	1	1	1	0.00%	–	1,649,142.44
20	EAC	0.01	0.001	0.001	0.00%	1,757,484.76	342,505,384.03
21	DAC	0.33	0.0063	0.006	-4.91%	579,224.99	17,935,932.41
22	WPL	1	0.1614	0.0705	-56.3%	1,181,183.66	868,457,967.3
23	ELFC	0.3	0.0089	0.0096	8.19%	7,751,345.20	620,256,078.002
24	ICTG	130	45.00	30.00	-33.33%	4,319,268.56	5,615,703,063.73

25	DC	1.20	0.39	0.21	-46.15%	4,726,121.69	217,410,099.87
26	ZESC	1	0.3453	0.2673	-22.59%	14,341,554.75	337,193,096.37
27	OBOT	114	239.06	96.89	-59.47%	395,497,604.54	4,150,656,018.7
28	MONT	1	1	1	0.00%	2,262.27	308,653,836.09
29	TRD	1	0.2	0.19	-5.00%	71,820,164.74	4,093,076,029.11
30	NTC	0.5	0.37	0.48	29.73%	12,712,848.26	6,729,959,108.00
31	CRX	15	0.6	0.51	-15.00%	32,391,364.21	289,915,687.59
32	ZOOS	1	0.55	0.55	0.00%	-	133,446,223.6
33	CPX	0.25	0.0155	0.0138	-10.9%	360,202.41	245,194,976.51
34	GER	0.1	0.0155	0.0155	0.00%	897,904.88	121,509,344.23
35	CARE	0.15	0.0072	0.0159	120.83%	78,003.19	29,969,054.88
36	CAEL	2.85	0.4573	0.0766	-83.25%	45,230.76	223,800,564.28
37	BDC	70	6.6353	36.7	453.1%	9,260.88	275,327,077.530
38	CAMEL	0.2	0.1685	0.1685	0.00%	-	16,811,780,181.6
39	MSC	0.25	0.1078	0.1501	39.24%	2,308,226.42	225,003,470.44
40	MOZO	0.3	0.0948	0.0025	-97.36%	272,378.91	473,773,684.808
41	MGLC	0.89	0.2551	0.2551	0.00%	-	70,129,135.01
42	IIT	3.00	0.35	0.35	0.00%	-	19,538,209.78
43	URGX	1	0.12	0.1	-16.67%	63,164,625.00	425,836,391.00
44	DAXT	1ARDT=	19.08	16.854	-11.67%	1,870,000,000.00	576,076,264.00
45	ARDM	1.333	0.015	0.011	-26.67%	97,399,369.00	1,062,101,499.00

2024 оны хоёрдугаар улирлын байдлаар бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр арилжаалагдаж буй дотоодын 45 виртуал хөрөнгө дунджаар 3 хувийн өсөлттэй байна. Дотоодын виртуал хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээ 161.5 тэрбум төгрөг болж өмнөх улирлаас 4.3%-иар буурчээ. Мөн тус улиралд дотоодын виртуал хөрөнгийн өдрийн дундаж арилжаа өмнөх улирлаас 2 дахин буурч, 100.2 сая төгрөг болсон байна.

Арилжааны дүнгээр авч үзвэл “ARDX, DAXT, BS9, SPC, IHC, OBOT, MNFT” гэх виртуал хөрөнгүүд нь энэ улиралд хамгийн өндөр дүнгээр арилжаалагдсан байна. Нийт 38 виртуал хөрөнгө анхны ханшнаасаа унасан, 8 виртуал хөрөнгө ханшийн өөрчлөлтгүй, 6 виртуал хөрөнгө арилжаалагдаагүй үзүүлэлттэй байна.

## Харилцагчийн мэдээлэл

Тус Хороонд бүртгэлтэй виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчдийн харилцагчид давхардсан тоогоор дараах байдалтай байна.

Хүснэгт 3. ВХҮҮ дээр бүртгэлтэй харилцагчдын мэдээлэл

№	Хуулийн этгээдийн нэр	Нийт бүртгэлтэй харилцагч	Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч	Нийт идэвхтэй харилцагч
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	216,950	83,846	2,376
2	“Койн Хаб” ХХК	196,037	119,627	16,564
3	“Айдакс” ХХК	164,012	114,497	1,925
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	13,869	4,977	31
5	“Корэкс” ХХК	65,155	30,460	41
6	“Икс Мета” ХХК	17,543	7,708	1,708
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	127,951	53,832	1,923
8	“Чойжин Алтекс” ХХК	727	339	89
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	2,228	1,183	0
10	“Капекс капитал” ХХК	32,881	15,999	61
11	“Анд дэнөүд” ХХК	3,144	588	4
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	43,161	2,464	14
<b>Нийт</b>		<b>883,658</b>	<b>435,520</b>	<b>24,736</b>


2024 оны хоёрдугаар улирлын байдлаар бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч дээр нийт 883,658 харилцагч бүртгэлтэй бөгөөд өмнөх улирлаас 0.98 хувиар өссөн үзүүлэлттэй байна.

## Хүснэгт 4. Нийт баталгаажуулалт хийсэн харилцагч


№	Хуулийн этгээдийн нэр	НИЙТ БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД				
		Дотоодын иргэн	Дотоодын хуулийн этгээд	Дотоодын улс төрд нөлөө бүхий этгээд	Гадаадын иргэн	Гадаадын хуулийн этгээд
1	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	83,728	24	59	35	0
2	“Койн Хаб” ХХК	119,510	16	20	81	0
3	“Айдакс” ХХК	65,641	20	0	48,836	0
4	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	4,964	2	0	11	0
5	“Корэкс” ХХК	30,450	10	0	0	0
6	“Икс Мета” ХХК	7,627	0	0	81	0
7	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	53,597	7	228	0	0
8	“Чойжин Алтекс” ХХК	331	8	0	0	0
9	“Зоос Дижитал Эксчэйнж” ХХК	1,183	0	0	0	0
10	“Капекс капитал” ХХК	15,581	0	0	418	0
11	“Анд дэнөөд” ХХК	585	2	0	1	0
12	“Поверэд Эй Ди Эм” ХХК	2,464	0	0	0	0

2024 оны хоёрдугаар улирлын байдлаар бүртгэлтэй виртуал хөрөнгийн үзүүлэгч дээр давхардсан тоогоор нийт 883,658 харилцагч бүртгэлтэй байна. Үүнээс 49.3 хувь буюу 435,520 харилцагч баталгаажуулалт хийсэн байна.


Зураг 4. Нийт харилцагчдын мэдээлэл



Зураг 5. Баталгаажуулалт хийсэн харилцагчийг төрлөөр ангилбал




Нийт баталгаажуулалт хийсэн 435,520 харилцагчийг төрлөөр ангилан харвал дотоодын иргэн хамгийн их буюу 385,661 харилцагч байна. Мөн дотоодын 89 хуулийн этгээд, гадаадын 43,463 иргэн тус тус харилцагчийн баталгаажуулалтыг хийсэн байна.




## БАТАЛГААЖУУЛАЛТ ХИЙСЭН ХАРИЛЦАГЧИД

## Насны бүлгээр




## Хүйсээр



Баталгаажуулалт хийсэн харилцагчийг нас, хүйсийн байдлаар задлан үзвэл дараах байдлаар харагдаж байна. Насны бүлгээрх ангиллыг харвал 31–45 насны харилцагчид дийлэнх хувийг эзэлж байна. Харин хүйсээр нь авч үзвэл эрэгтэй харилцагчид баталгаажуулалт хийж арилжаанд оролцох нь илүү байгааг харж болно.

## Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл



Хорооны 2024 оны хоёрдугаар улирлын байдлаар “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу хийсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 12 ВХҮҮ-ийн төрөлх эрсдэл дундаж, бизнесийн болон бүтцийн эрсдэл мөн адил өндөр байна. Мөн тус байгууллагуудыг үйл ажиллагааны идэвхтэй байдал, арилжааны хэмжээ, харилцагчдын тоо, байгууллагын хэмжээ зэрэг хүчин зүйлсийг харгалзаж үнэлсэн болно.

Хүснэгт 5. МУТСТ эрсдэлийн үнэлгээ

ЭРСДЭЛ МАШ БАГА	ЭРСДЭЛ БАГА	ЭРСДЭЛ ДУНДАЖААС ДООШ	ЭРСДЭЛ ДУНДАЖ	ЭРСДЭЛ ДУНДАЖААС ДЭЭШ	ЭРСДЭЛ ӨНДӨР
“Поверэд Эй Ди Эм” ХХК	“Нэйшнал Трэйшир Бит Секьюрити” ХХК	-	“Дижитал Эксчейнж Монголиа” ХХК	-	-
-	“Комплекс Дижитал Экосистем” ХХК	-	“Койн Хаб” ХХК	-	-
-	“Чойжин Алтекс” ХХК	-	“Айдакс” ХХК	-	-
-	“Капекс капитал” ХХК	-	“Икс Мета” ХХК	-	-
-	“Анд дэнөөд” ХХК	-	-	-	-
-	“Зоос Дижитал Эксчейнж” ХХК	-	-	-	-

Хорооноос нийт зохицуулалтын салбарын мэдээлэх үүрэгтэй этгээдэд эрсдэлд суурилсан хяналт шалгалтыг хэрэгжүүлж ажилладаг бөгөөд хагас жил тутам мэдээлэх үүрэгтэй этгээд тус бүрийн эрсдэлийг үнэлж, эрсдэлийн хувийн хэрэг үүсгэн ажиллаж байна. Хорооны 2023 оны 22 дугаар тогтоолоор шинэчлэн батлагдсан “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр банкнаас бусад мэдээлэх үүрэгтэй этгээдэд зайны болон газар дээрх хяналт шалгалт хийх журам”-ын дагуу бүртгэлтэй ВХҮҮ-ийн эрсдэлийг “Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх, үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх эрсдэлийн үнэлгээний асуулга”-ын дагуу үнэлсэн.


2024 оны хоёрдугаар улирлын байдлаар хийсэн мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний үр дүнгээс үзэхэд Монгол Улсад үйл ажиллагаа явуулж буй 12 ВХҮҮ-ээс 6 нь бага эрсдэлтэй, 1 нь эрсдэл маш бага, 4 нь дундаж буюу салбарын оролцогчдын 33% буюу 4 ВХҮҮ нь цаашид эрсдэлийг бууруулах арга хэмжээг сайжруулах шаардлагатай. Тус 4 ВХҮҮ-ийн эрсдэлийн үнэлгээг байгууллагын хэмжээ, арилжааны дүн, арилжаанд оролцогчдын төрөл зэрэг хүчин зүйлс нэмэгдүүлж байгаа буюу бизнесийн болон бүтцийн эрсдэл өндөртэй байна. “Корекс” ХХК –ийн ирүүлсэн мэдээлэл алдаа заасан тул үнэлгээнд ороогүй болно.

## ВХҮҮ–ийн санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2024 оны хоёрдугаар улирлын санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт хөрөнгийн дүн 65.9 тэрбум төгрөг бөгөөд үүнээс эргэлтийн хөрөнгө 47.2 тэрбум төгрөг, эргэлтийн бус хөрөнгө 18.7 тэрбум төгрөг байна.

Нийт өр төлбөр ба эздийн өмчийн дүн 65.9 тэрбум төгрөг бөгөөд үүнээс өр төлбөрийн дүн 45.4 тэрбум төгрөг, эздийн өмчийн дүн 20.5 тэрбум төгрөг байна.

## НИЙТ ХӨРӨНГӨ \ХУВИАР\



## ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ ХУВИАР\



## Хүснэгт 6. Орлогын дэлгэрэнгүй тайлан \төгрөгөөр\

№	Үзүүлэлт	2024.03.31–ны байдлаар	2024.06.30–ны байдлаар
1	Борлуулалтын орлого (цэвэр)	1,265,752,167.58	2,490,014,117.11
2	Борлуулалтын өртөг	321,493,323.42	482,587,223.73
3	Нийт ашиг	944,258,844.16	2,007,426,893.37
4	Тайлан үеийн цэвэр ашиг (алдагдал)	3,042,368,874.06	(498,324,521.64)
5	Орлогын дүн	5,601,250,251.97	5,269,219,696.5

Бүртгэлтэй 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгчийн 2024 оны хоёрдугаар улирлын орлогын дэлгэрэнгүй тайлангийн үзүүлэлтүүдийг нэгтгэн харахад нийт орлогын дүн 5.27 тэрбум төгрөг, нийт зардал 5.76 тэрбум төгрөг байна. Мөн тус улиралд дээрх 12 виртуал хөрөнгийн үйлчилгээ үзүүлэгч нь нийтдээ 498.3 сая төгрөгийн алдагдалтай ажилласан байна. Өмнөх улирлын мөн үетэй харьцуулахад нийт орлогын дүн 332 сая төгрөгөөр буюу 5.93 хувиар буурсан бол нийт зардал 3.2 тэрбум төгрөгөөр буюу 1.2 дахин өссөн дүнтэй үзүүлэлттэй байна.



Засгийн газрын 4 байр, Бага тойруу-3, Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, Монгол Улс 15160



+976-51-261674



[www.frc.mn](http://www.frc.mn)



[vaspd@frc.mn](mailto:vaspd@frc.mn)



Санхүүгийн зохицуулах хороо



@FRC\_of\_Mongolia